



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/221

Хэрлэн сум

**Малын сэг зэм устгах шатахууны
зардалд хөрөнгө зарцуулах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1, аймгийн Онцгой комиссын 10 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан малын сэг зэм устгах шатахууны зардалд 39,000,000 (гучин есөн сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар захирамжийн хавсралт

ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ СУМДЫН ЖАГСААЛТ

Д/д	Сумд	Мөнгөн дүн
1.	Галшар	10,000,000
2.	Баянхутаг	5,000,000
3.	Дархан	5,000,000
4.	Дэлгэрхаан	3,000,000
5.	Жаргалтхаан	3,000,000
6.	Мөрөн	3,000,000
7.	Өмнөдэлгэр	3,000,000
8.	Баян Овоо	3,000,000
9.	Батноров	3,000,000
10.	Гурванбаян	1,000,000
	НИЙТ	39,000,000